

БАТЛАВ.

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН”
УТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭРДЭНЭБАЯР

9024090461 7065385 ШЖР1111

ЗҮҮН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ТЕХНИК ЭДИЙН
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр

№ 0-01/02

Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Ерөнхий шаардлага
1	Үндэслэл	<ul style="list-style-type: none">Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор “2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3.1 дэх хэсэг, 5.1-5.7 дахь хэсэг, 6.1.3 дахь заалт.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5. “Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах хөгжлийн зорилtot хөтөлбөр байна. 6.5.6 бүсийн хөгжлийн зорилtot хөтөлбөр” гэж заасан.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого “Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах, бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж иргэдэд таатай эрүүл аюулгүй байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ” гэж заасан.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын IV.4.4.1-д “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг

		төсөв /Улсын хэмжээнд/-ийг боловсруулахаар тусгагдсан.
2	Ажлын зорилго	<ul style="list-style-type: none"> ▪ Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийн хувилбар боловсруулах; ▪ Аймгийн хөгжлийн бодлогод тусгах төсөл, арга хэмжээний санал боловсруулах; ▪ Бүс, аймаг, сумын хэмжээнд эдийн засгийн салбаруудын нөөц, хөдөлмөрийн нөөц, чадавх, урсгалыг тодорхойлох; ▪ Бүс, аймаг, сумын байгаль экологи, түүх, археологи, нүүдлийн өв соёлын давуу тал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, аймгуудын, сумдын хоршилт, төрөлжилт, дагналтыг тодорхойлох; ▪ Бүсийн, аймгийн, сумын эдийн засгийн тэргүүлэх чиглэлд уялдсан стратеги төлөвлөгөөний санал, зорилго, зорилтыг тодорхойлох; ▪ Бүс дэх аймгуудын хоршилт, төрөлжилт, дагналтыг тодорхойлох, сумуудын хамтын ажиллагааны төрөл хэлбэр, гүйцэтгэх үүргийг тодорхойлох; ▪ Бүсийн хөгжлийг дэмжих удирдлага зохион байгуулалт, төсөв санхүүгийн тогтолцоо, татварын эрх зүйн орчныг тодорхойлох; ▪ Бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжсэн ажлын байр бий болгох төсөл, арга хэмжээний санал, эрэмбийг тодорхойлох; ▪ Бүсийн эдийн засгийн өсөлтийн загвар боловсруулах; ▪ Бүсийн хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээний байршил, эдийн засгийн үр ашгийн судалгаа, тооцоолол, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулах; ▪ Бүсийн хөгжилд хувийн хэвшил, хоршоодын оролцоог тодорхойлох; ▪ Бүсэд шинээр бий болох ажлын байр, шилжилт хөдөлгөөн, татах чадвар зэргийг үнэлж тооцоолно.
3	Хэрэгцээ шаардлага	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д төлөвлөлтийн баримт бичгийг урт, дунд, богино хугацааны төрөлтэй байхаар тогтоосон ба дээрх зүйлийн 6.5-д дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна гэж заасан. Хөгжлийн зорилтод 8 хөтөлбөрийн нэг нь бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр юм.</p> <p>Монгол Улсын Их Хурал 2001 оны 57-р тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталснаас хойш 22 жилийн хугацаа өнгөрсний дараа</p>

		<p>2024 онд Улсын Их Хурлын 64-р тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн баталсан. Өнгөрсөн 22 жилийн хугацаанд Улаанбаатар хотод хэт төвлөрөл бий болж, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж харьцангуй хязгаарлагдмал байдалтай болсон. Нийслэл хот руу жилд дунджаар 30 мянган иргэн шилжин суурьшдаг. Тэдний дийлэнх нь чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, илүү санхүүгийн боломж хайж, Улаанбаатар хотод шилжин суурьшиж байгаа нь хот хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг илэрхийлж байна.</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийн талбай бүхий нийслэл Улаанбаатар хотод нийт хүн амын 46.8 хувь нь амьдарч, ААН-ийн 75.8 хувь үйл ажиллагаа явуулж байгаа нь орон зайн хувьд хөгжлийн хэт ялгаатай тэнцвэргүй байдлыг үүсгэсэн. Үүний улмаас орон нутагт ажиллах хүчний дутагдал үүсэж, нутаг дэвсгэрийн хувьд эдийн засгийн төрөлжилт, хоршилт алдагдаж, хүн амын зохисгүй төвлөрөл, түгжрэл, утаа, агаар хөрсний бохирдол бий болгож, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг бууруулж байна.</p> <p>Иймд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д нийцүүлэн “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх) боловсруулах шаардлага үүсээд байна.</p>
4	Ажлын иж бүрдэл	<p>ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>Суурь судалгаа:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хууль эрхзүйн орчин, бодлогын баримт бичгийн судалгаа, нийцэл; ▪ Бүсийн эдийн засгийн өнөөгийн байдал, дүн шинжилгээ; ▪ Хүн ам зүйн болон ажиллах хүчний судалгаа; ▪ Байгаль орчны суурь судалгаа; ▪ Нийгмийн судалгаа; ▪ Харьяалагдах аймгийн хөгжлийн ерөнхий судалгаа; ▪ Эдийн засгийн эргэлтэд оруулах боломжит нөөцийн судалгаа; ▪ Чөлөөт бүс, тусгай бүс, боомтын хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгаа; ▪ Эдийн засгийн коридорын төсөл санаачилгуудын дүн шинжилгээ, судалгаа; ▪ Бүс нутгийн хоорондын болон хөрш орнуудын хөгжлийн бодлогын судалгаа; ▪ Бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээ; ▪ Бүсийн тээвэр логистикийн тогтолцоо, хэрэгцээний судалгаа;

- Төсөв санхүүгийн бодлого (татвар), олон улс дахь харьцуулалтын судалгаа;
- Бодлогын нөлөөтэй аймаг, орон нутгийн эдийн засгийн өсөлтийн загварын судалгаа;
- Бүсийн удирдлага зохион байгуулалт, олон улсын туршлагын судалгаа, нутагшуулах талаар санал дүгнэлт.

Бүсийн хөгжил байршлын орон зайн төлөвлөлтийн зураглал:

Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хөгжил байршлын орон зайн төлөвлөлтийн зураглалын хүрээнд дараах газрын зургийг боловсруулсан байна. Үүнд:

- Бүсийн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээний зураглал;
- Бүсийн байгалийн нөхцөл нөөцийн зураглал /геоморфологи, геоморфологийн мужлалт, гадаргын эгц налуу, уул зүй, гадаргын хэрчигдэл, элсний мужлал/;
- Геологийн тогтоц, ашигт малтмалын зураглал /геологи ашигт малтмалын газар хөдлөлтийн мужлал, инженер геологийн нөхцөл, гидреологийн мужлал/;
- Бүсийн уур амьсгалын зураглал /агаарын температур, нарны нийлбэр цацраг, агаарын даралт, хур тунадас, агаарын харьцангуй чийг, уур амьсгалын мужлал/;
- Гадаргын ус /ус зүйн сүлжээ, голын сүлжээний нягтшил, гол мөрний усны горим, усны нөөц, ашиглалт, нуур, гүний усны нөөц/;
- Хөрс /хөрс, хөрс-газарзүйн мужлалт, хөрсний эвдрэл, хөрсний тархалт/;
- Ургамалшил /ургамалшил ой, ургамалшлын мужлал/;
- Ландшафт, байгалийн мужлал;
- Хүн амын нягтшил, хот суурины байршлын зураглал /хүн ам, хот, хөдөөгийн хүн ам, хүн амын нягтшил, суурин газрын хөдөлмөр эрхлэлтийн хуваарилалт/;
- Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо, мужлал;
- Бүсийн нийгмийн үйлчилгээний салбарын зураглал /боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт/;
- Хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөний зураглал;
- Хот суурины төвлөрөл өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын зураглал;
- Хөдөө аж ахуй, нөөцийн судалгаа /хөдөө аж ахуйн эдэлбэр газар, тариалангийн эдэлбэр газар, хадлан, бэлчээрийн хэв шинж, адтуу, үхэр, хонь, ямаа, тэмээ, шувууны аж ахуй, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, газар тариалангийн нийт бүтээгдэхүүн/;

		<ul style="list-style-type: none"> ▪ Хүнсний үйлдвэрлэл хөгжих аймаг, орон нутгийн тохиромжтой байдлын үнэлгээний зураглал /махны үйлдвэрлэл, сүүний үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх аймаг, орон нутаг/; ▪ Хөнгөн үйлдвэр хөгжих аймаг, орон нутгийн тохиромжтой байдлын үнэлгээний зураглал /ноосны үйлдвэр, арьс ширний үйлдвэр, ноолуурын үйлдвэр, оёдол модон эдлэлийн үйлдвэр, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, хөнгөн үйлдвэр хөгжүүлэх аймаг, орон нутаг/; ▪ Хүнд үйлдвэр хөгжих аймаг, орон нутгийн тохиромжтой байдлын үнэлгээний зураглал /алт олборлох, боловсруулах үйлдвэр, зэс олборлох боловсруулах үйлдвэр, тэмрийн хүдэр олборлох, боловсруулах үйлдвэр, нүурс олборлох боловсруулах үйлдвэр, газрын тос олборлох, боловсруулах үйлдвэр, холимог металл олборлох боловсруулах үйлдвэрлэл, ховор метал олборлох, боловсруулах үйлдвэр, хүнд үйлдвэр хөгжүүлэх аймаг, орон нутаг/; ▪ Барилгын материалын үйлдвэр хөгжих аймаг, орон нутгийн тохиромжтой байдлын үнэлгээний зураглал; ▪ Үйлдвэрлэлийн кластер, үйлдвэржилтийн хөгжил, байршлын орон зайн нэгдсэн төлөвлөлтийн зураглал; ▪ Аялал жуулчлалын тохиромжтой байдлын үнэлгээний зураглал; ▪ Амралт сувилал, соёлын биет болон биет бус өв, аялал жуулчлалын кластер, нийлүүлэлтийн сүлжээ төлөвлөлтийн зураглал; ▪ Бус дэх аймгууд, эдийн засгийн өсөлтийн төвүүдийн эдийн засгийн чиг үүргийн зураглал; <p>Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн агуулга, зорилт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл; ▪ Бодлогын төсөл боловсруулах аргачлал, арга зүй; ▪ Нөхцөл байдлын дүн шинжилгээ; ▪ Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ; ▪ Бодлогын баримт бичгийн ерөнхий мэдээлэл; ▪ Бодлогын төслийн стратеги зураглал; ▪ Бодлогын зорилго, зорилт; ▪ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа, төлөвлөгөө; ▪ Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн шалгуур үзүүлэлт; ▪ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр;
--	--	---

		<ul style="list-style-type: none"> ▪ Хөтөлбөрийн хэрэгжилтэд учирч болох эрсдлүүдийг тодорхойлох, даван туулах менежментийн төлөвлөгөө, санал боловсруулах; ▪ Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө; ▪ Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийг /аймаг тус бүрт болон бүсэд З хүртэл удаа/ олон талын оролцоог хангаж, зохион байгуулсан байна. <p>Хөтөлбөрийн санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо</p> <ul style="list-style-type: none"> ▪ Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө; ▪ Хөрөнгө оруулалтын тооцоо, эх үүсвэр, үе шат; ▪ Төслүүдийн үр ашгийн тооцоо; ▪ Хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо; <p>Хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж</p> <ul style="list-style-type: none"> ▪ Төслүүдийг хэрэгжүүлэх газрын байршил; ▪ Инженерийн дэд бүтцийн хангамж; ▪ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан /богино, дунд, урт хугацааны/ төлөвлөгөө, үе шат; ▪ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж. <p>Загвар зураг:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөний загвар зураг, хувилбарууд;
5	Ашиглах материал	<p>Хууль, дүрэм журам:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Үндсэн хууль ▪ Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль ▪ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль ▪ Төсвийн тухай хууль ▪ Татварын ерөнхий хууль ▪ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ▪ Хот байгуулалтын тухай хууль ▪ Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль ▪ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль ▪ Газрын тухай хууль ▪ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль ▪ Барилгын тухай хууль ▪ Байгаль орчныг хамгаалах тухай хууль ▪ Усны тухай хууль ▪ Ойн тухай хууль ▪ Монгол Улсын инновацийн тухай хууль ▪ Эрчим хүчний тухай хууль ▪ Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль ▪ Хөрс хамгаалах тухай хууль ▪ Газрын хэвлэлийн тухай хууль ▪ Харилцаа холбооны тухай хууль ▪ Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/25 дугаар

		<p>тушаалаар батлагдсан “Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал”</p> <ul style="list-style-type: none"> ▪ Бусад хууль, дүрэм журам
6	Тайлан боловсруулах үе шатууд	<p>I. Эхний үе шатны тайлан /гэрээ байгуулснаас хойш 45 хоногийн дараа/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эхлэлийн тайлан болон Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах арга зүйн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. ▪ Бүсчилсэн хөгжлийн хүрээнд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаж буй байдалд дүн шинжилгээ хийсэн санал, дүгнэлт, зөвлөмж нөхцөл байдлын дүн шинжилгээний тайланг боловсруулсан байна. <p>II. Хоёр дахь үе шатны тайлан /гэрээ байгуулснаас хойш 4 сарын дараа/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Суурь судалгааны үр дүн. ▪ Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн эхний төсөл, дунд хугацааны тайланг боловсруулна. ▪ Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийн хөгжил, байршил, орон зайн төлөвлөлтийн зураглалыг салбар тус бүрээр боловсруулна. ▪ Аймгуудад хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. <p>III. Гурав дахь үе шатны тайлан /гэрээ байгуулснаас хойш 7 сарын дараа/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Тайланг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг хавсаргасан байна. ▪ Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн эцсийн тайланг “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-ын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хүлээлгэн өгнө. ▪ Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл, салбаруудын хөгжил, байршлын орон зайн төлөвлөлтийн зураглалыг салбар тус бүрээр боловсруулж, атласын эхийг бэлдсэн байна. ▪ Газрын зургийн дата мэдээллийг shp өргөтгөлөөр, диаграмм, хүснэгт, хавсралт, ашигласан материалын жагсаалтыг

		<p>хавсарган файлаар захиалагч талд ирүүлсэн байна.</p> <p>IV. Дөрөв дэх үе шатны тайлан /гэрээ байгуулснаас хойш 8 сар 15 хоногийн дараа/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг Улсын Их Хурлаар болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах үйл ажиллагаанд оролцно.
7	Захиалагч байгууллага	“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ
8	Тендерт оролцогчийн багийн гишүүдэд тавигдах шаардлага	<p>Зөвлөх хуулийн этгээд нь бүс нутгийн төлөвлөлтийн арга зүй аргачлалтай, санхүүгийн загварчлал болон эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний судалгаа боловсруулалтын ажлын туршлагатай, мэдээллийн бааз бүрдүүлэхэд шаардагдах мэдээллийн технологийн мэдлэг чадвартай ажилчид, тоног төхөөрөмжтэй байх бөгөөд 15 хүний бүрэлдэхүүн /ажлын цар хүрээнээс хамаарч нэмэгдэж болох ба үүгээр хязгаарлагдахгүй/-тэй байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ахлах зөвлөх 2. Хууль, эрх зүйн асуудал хариуцсан зөвлөх 3. Эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх 4. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан зөвлөх 5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал хариуцсан зөвлөх 6. Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан зөвлөх 7. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх 8. Байгаль орчин, газарзүйн асуудал хариуцсан зөвлөх 9. Хот төлөвлөлтийн асуудал хариуцсан зөвлөх 10. Тээвэр логистикийн асуудал хариуцсан зөвлөх 11. Нийгмийн салбар, хүн ам зүйн асуудал хариуцсан зөвлөх 12. Эрчим хүчний салбарын асуудал хариуцсан зөвлөх 13. Аялал жуулчлалын салбарын асуудал хариуцсан зөвлөх 14. Санхүү, татварын асуудал хариуцсан зөвлөх 15. Газарзүйн мэдээллийн систем, газрын зураг боловсруулах зөвлөх 16. Математик загварчлал хариуцсан зөвлөх
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 9 сар
10	Гүйцэтгэгч байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд
11	Санхүүжилт, эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
12	Хүлээн авах баримт	Ажлын бүрдэл хэсэгт туссан судалгаа шинжилгээний зураглал, тайлан тооцоо, видео зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн программ хангамжийн эх

		хувилбараар “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” ҮТҮГ-т хүлээлгэж өгөх /4 хувь/.
--	--	---